



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 8/324

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүрд сумын нутаг дэвсгэр дэх “Тарнын гүүрний хяналтын цэг”-т ажиллах албан хаагчдын үйл ажиллагаанд шаардагдах зардал 13,198,200 (арван гурван сая нэг зуун ерэн найман мянга хоёр зуу) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

2.Хяналтын постод ажиллах албан хаагчдын ажил үүргийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг хангуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100699

Аймгийн Засаг даргын 2021 оны 06..
дугаар сарын 27.-ны өдрийн 1/2021 дүгээр
захирамжийн хавсралт



БҮРД СУМЫН ТАРНЫН ПОСТЫН ЗАРДЛЫН НЭМЭЛТ ТООЦОО

№	Шаардагдах хэрэгсэл	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1. Үйл ажиллагааны зардал				
1	Хоол	47 хоног /12 хүн/	21000	11,844,000
3	Албан хаагчдын машинд бензин	1 хоногт-15л 47хоногт-705л	1500	1,057,500
5	цэвэрлэгээний алчуур	6ш	8000	48,000
6	Хогийн уут	15 боодол	5500	82,500
7	3 өнгө алчуур	6хос	5500	33,000
8	Гарын шингэн саван	5ш	6000	30,000
9	Белизна	3ш	3400	10,200
10	Цэвэр ус (баллонтой)	10	3500	35,000
11	Кофе	4 уут	14500	58,000
Нийт дүн				13,198,200